

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БАЯННУУР СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитын код: БУА-2025/014/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2025 он

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг:
enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Д.Даариймаа
Утас: 70342495 Цахим хаяг:
daariimaado@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.03.13

№ 336

танил _____ ны № _____ т

**БАЯННУУР СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.ЁНДОН ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Баяннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг аймгийн төсвөөс 943,512.9 мянган төгрөг, орон нутгийн татварын орлогоос 404,027.7 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн дэмжлэг 243,701.9 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 70,000.0 мянган төгрөг, тусгай сангуудын эх үүсвэрийг 259,458.5 мянган төгрөг нийт зарлагыг 2,006,626.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй төлөвлөсөн боловч орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт өссөн, засгийн газрын тогтоолоор цалин нэмэгдсэн, оны эхний үлдэгдлийг нэмж баталсан шалтгаалаан нэмэгдсэн байна.

632592662

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тайлант онд авлагын оны эхний үлдэгдэл 247,198.8 мянган төгрөг тайлант онд 25,700.7 мянган төгрөгийн авлага нэмэгдэж 47,456.2 мянган төгрөгөөр бууруулж жилийн эцсийн үлдэгдэл 199,742.6 мянган төгрөгийн болсон нь авлагын өмнөх оноос 20 хувиар бууруулан ажигласан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

АДБОУС 2706 10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүссэн тухай, санхүүгийн тайлангийн аудит, аудитын тайлантай холбоотой аудиторовн хүлээх үүрэг хариуцлагын тухай дэлгэрэнгүй тайлбар өгөхөөр хууль тогтоомжоор шаардсан мэдээллийг тусгана.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Ж.ЭНХЦООДОЛ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлт

	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	576,116,082.66	701,631,172.51
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,368,654,277.93	2,476,605,887.46
	Нийт хөрөнгийн дүн	2,944,770,360.59	3,178,237,059.97
	Нийт өр төлбөрийн дүн	35,071,774.00	14,725,874.00
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,909,698,586.59	3,163,511,185.97
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,944,770,360.59	3,178,237,059.97
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	3,064,962,401.07	3,441,156,247.08
	Үйл ажиллагааны зардлын дүн	2,531,291,328.88	3,180,763,309.70
	Үйл ажиллагааны үр дүн	533,671,072.19	260,392,937.38
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	436,186,958.61	260,392,937.38
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл		2,909,698,586.59
	Тайлант оны үр дүн		260,392,937.38
	Эцсийн үлдэгдэл		3,163,511,185.97
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,714,826,087.82	3,398,919,583.61
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,158,624,964.00	2,819,548,386.11
	Үйл ажиллагааны ЦМГ	556,201,123.82	579,371,197.50
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-437,099,102.00	-219,063,800.00
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-120,737,726.00	-110,068,800.00
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-1,635,704.18	250,238,597.50
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	199,231,024.83	197,595,320.65
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	197,595,320.65	447,833,918.15
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,013,580,000.00	1,623,975,486.11
	Урсгал зардал	1,417,540,600.00	1,305,807,686.11
	Хөрөнгийн зардал	336,580,900.00	208,099,000.00
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,013,580,000.00	1,842,339,116.00
	Орон нутгийн төсвөөс	1,397,640,600.00	1,409,990,600.00
	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	243,780,900.00	274,301,000.00

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Засаг даргын Тамгын газар нь УИХ, Засгийн газрын тогтоол шийдвэр, Засгийн газар болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрүүд, сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагааг чиглэл болгон ажиллаж байна.

Байгууллагын зорилго- Оновчтой бодлого зохицуулалтаар сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлж, иргэдийнхээ орон нутагтаа ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэхэд оршино.

Байгууллагын зорилт- Сумын Засаг даргын Тамгын газар нь хууль тогтоомжоор олгогдсон үндсэн чиг үүрэг, түүнд нийцүүлэн сумын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн оновтой бодлого, зохицуулалтаар хангах,

Сумын нийгмийн салбарын хөгжлийг ахиулахад чиглэсэн оновтой бодлого, зохицуулалтаар хангах,

Захиргааны удирдлага, иргэдэд үзүүлж буй захиргааны үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлэх, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх замаар байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад тус тус оршино.

Дөрөв. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлууд

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 233.5 сая төгрөгөөр буюу 7.9 хувиар өссөн байна.

Тав. Аудитын гол асуудал

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг аймгийн төсвөөс 943,512.9 мянган төгрөг, орон нутгийн татварын орлогоос 404,027.7 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн дэмжлэг 243,701.9 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 70,000.0 мянган төгрөг, тусгай сангуудын эх үүсвэрийг 259,458.5 мянган төгрөг нийт зарлагыг 2,006,626.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 943,512.9 мянган төгрөгийг аймгийн төсвөөс, 404,027.7 мянган төгрөгийг орон нутгийн татварын орлогыг бүрдүүлсэн байна.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2024 оны Шилэн дансны мэдээллийг Шилэн дансны тухай хуулиар 145 мэдээлэл оруулахаас 143 мэдээллийг хугацаанд нь мэдээлж 2 мэдээг хугацааг хоцроон мэдээлсэн байна

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

Найм. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 187.5 сая төгрөгийн алдаа илэрснээс 187.5 сая төгрөгийн алдааг залруулан ажиллаа.

5.1 Төлбөрийн акт Байхгүй

5.2 Албан шаардлага Байхгүй

[illegible]